

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Монгол улс, Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал баг
Хөвсгөл Алтандуулга ХК, Утас: 70386030, Факс: 70386031

Огноо 2026-04-30

№ 05

ТУЗ-ийн даргыг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 78.1, Компанийн дүрмийн 7.29 дэх заалтыг үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Доржпүрэвийн Батхуягийг сонгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮД:



Д.БАТХУЯГ

Л.ДАВАА

Д.ДУЛАМСҮРЭН

М.ЗОЛЗАЯА

М.ЗУЛЗАЯА

Б.МАНДХАЙ

Ц.НАРАН-УЧРАЛ

Д.ЭНХТОГТОХ

Ш.ЭНХМЭНД

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Монгол улс, Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал баг
Хөвсгөл Алтандуулга ХК, Утас: 70386030, Факс: 70386031

Огноо 2026.04.30

№ 06

Хороод байгуулж, бүрэлдэхүүнийг
батлах тухай

Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 81.2, “Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн дүрмийн 7.45 дахь заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хороод, түүний бүрэлдэхүүнийг доорхи байдлаар баталсугай. Үүнд:

1/ Аудитын хороо

Хорооны дарга:

Гишүүд:

Ш.Энхмэнд (хараат бус)

Д.Энхтогтох (хараат бус)

Л.Даваа

М.Золзаяа

М.Зулзаяа

2/ Нэр дэвшүүлэх хороо

Хорооны дарга:

Гишүүд:

Ц. Наран-Учрал (хараат бус)

Д.Энхтогтох (хараат бус)

Л.Даваа

Д.Дуламсүрэн

Д. Мандхай

3/ Цалин, урамшууллын хороо

Хорооны дарга:

Гишүүд:

Д.Энхтогтох (хараат бус)

Ш.Энхмэнд (хараат бус)

Д.Батхуяг

Д.Дуламсүрэн

М.Золзаяа

2. Компанийн тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн Засаглалын кодекс, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны То-18-07 дугаартай тогтоолоор батлагдсан “Хороодын ажиллах журам”-ыг мөрдөж ажиллахыг хороодын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Хороод байгуулж, бүрэлдэхүүнийг батлах тухай” Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 03 дугаартай тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА



Д.БАТХУЯГ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Монгол улс, Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал баг
Хөвсгөл Алтандуулга ХК, Утас: 70386030, Факс: 70386031

Огноо 2026.04.30

№ 08.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 61 дүгээр зүйлийн 61.1.5, 76 дугаар зүйлийн 76.1.2, “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ын 2.3 дах заалт, “Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн 7.2, 7.6 дах заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 11.00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүргийн 8 дугаар хороо, 11 дүгээр хороолол, Ж.Батмөнхийн гудамж, 39-2 тоотод байрлах “Велокс” оффист хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар “Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцүүлэхээр тогтоосугай.

3. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн санал өгөх “Саналын хуудас”-ны агуулгыг хавсралт ёсоор баталсугай.

4. Компанийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.2-т заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 05 дугаар сарын 19-ний өдрөөр тогтоосугай.

5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хурлын зарыг 2026 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн дотор Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас болон компанийн өөрийн цахим хуудсаар, 2026 оны 05 дугаар сарын 12-ны өдөр болон 05 дугаар сарын 28-ны өдрийн “Өдрийн сонин”, “Өнөөдөр” сониноор дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэх “Компанийн дүрэмд орох нэмэлт, өөрчлөлтийн төсөл”-ийг 2026 оны 05 дугаар сарын 08-ны дотор бэлэн болгохыг Гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнэд үүрэг болгосугай.


7. Хувьцаа эзэмшигч нь ээлжит бус хурлаар хэлэлцэх асуудлыг 2026 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн дотор ажлын өдрүүдэд 11.00-16.00 цагийн хооронд Улаанбаатар хот, 8 дугаар хороо, 11 дүгээр хороолол, Ж.Батмөнхийн гудамж 39-2, “Велокс” оффис болон Хөвсгөл аймаг, Тариалан суманд байрлах компанийн байранд ирж танилцах, саналаа урьдчилан өгөх боломжтой болохыг дурьдсугай.

8.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Батхуягийг, хурал зохион байгуулах комиссын даргаар Компанийн Гүйцэтгэх захирал Г.Бат-Эрдэнийг тус тус томилсугай.

9.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын даргаар “Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн Борлуулалтын менежер Нанжидын Ганзориг, гишүүдээр хувьцаа эзэмшигч Сэрээтэрийн Оюунгэрэл, Болдбаатарын Гантулга нарыг тус тус томилсугай.

10.Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын мэдэгдлийг Монголын Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороо болон эрх бүхий бусад этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хүргүүлж хариуцлагатай ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн дарга (М.Зулзаяа)-д, хурал зохион байгуулахтай холбоотой шаардлагатай дэмжлэг үзүүлж, холбогдох зардлыг санхүүжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Бат-Эрдэнэ), Ерөнхий нягтлан бодогч (Ж.Отгонням) нарт тус тус даалгасугай.





“Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 04 сарын 30-ны өдрийн 08 тоот тогтоолын хавсралт

**“ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА” ХУВЬЦААТ КОМПАНИ
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛД ОРОЛЦОГЧДООС
САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог нэр

Регистерийн дугаар.....

Санал өгөх хувьцааны тоо

Үйлчилсэн /Үнэт цаасны компани /

“Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2026 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 11.00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, 11 дүгээр хороолол, Ж.Батмөнхийн гудамж, 39-2 тоотод байрлах “Велокс” оффист болно.

№	Хэлэлцэх асуудал	Тухайн асуудлаар гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Түдгэлзсэн	Таагалзсан	Таагалзсан бол таны өгөх санал
1	Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах	Тогтоол №01				

(Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэг + тэмдгийг бичнэ үү)

Хувьцаа эзэмшигч:..... /гарын үсэг/

2026 оны дугаар сарын-ны өдөр

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Монгол улс, Хөвсгөл аймаг, Тариалан сум, Мандал баг
Хөвсгөл Алтандуулга ХК, Утас: 70386030, Факс: 70386031

Огноо 2026.04.30

№ 07

ТУЗ-ийн нарийн бичгийн даргын
үүрэгт ажлаас чөлөөлж, шинээр
томилох тухай

Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1, “Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн дүрмийн 7.52 дах заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1.Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн дарга С.Оюунгэрэлийн өөрийн хүсэлтийн дагуу “Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас 2026 оны 05 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн чөлөөлсүгэй.

2.Мандширын Зулзаяаг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс “Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн даргын үүрэгт ажилд томилсугай.

3.Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн дарга М.Зулзаяад олгох нэг сарын үндсэн цалинг 2,000,000 (хоёр сая) төгрөгөөр тогтоож, батлагдсан төсвийн дагуу сар бүр олгож байхыг Ерөнхий нягтлан бодогч (Ж.Отгонням)-д даалгасугай.

4.М.Зулзаяад Компанийн тухай Монгол Улсын хууль тогтоомж, “Хөвсгөл Алтандуулга” ХК-ийн дүрэм, холбогдох журмыг чанд мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.

5.Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Нарийн бичгийн дарга шинээр томилогдсонтой холбоотойгоор компанийн Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу зохих ёсоор ажлаа хүлээлцэхийг С.Оюунгэрэл, М.Зулзаяа нарт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА Д.БАТХУЯГ

